

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

ГХБХБГазар

2025.06.25

Д/д	Гэрээний үүрэг	Үүргийн хэрэгжилт	Хувь
2.1	“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд		
2.1.1	Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын “Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил” 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ (төлөвлөлт, явц, гүйцэтгэл) хийж, хэрэгжилтийг хангах	Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын “Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил” 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус байгууллагатай холбоотой 26 арга хэмжээ, Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан тус байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах 9 зорилт бүхий 29 арга хэмжээний хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг гаргаж тус байгууллагын 2025 оны 342, 376 дугаартай албан бичгээр аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажилласан.	100
2.1.2	Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн төслийн жагсаалтад орсон хөтөлбөр, төслүүдийг товлосон хугацаанд нь хэрэгжүүлэх;	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг бүрэн хэрэгжүүлэхэд малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар газар олгох асуудлыг орон нутагт зохион байгуулан ажиллаж, Алтанширээ, Замын-Үүд, Улаанбадрах, Иххэт, Сайншанд зэрэг суманд 8 малчдын хоршоонд 29.09 га газрыг төсөл сонгон шалгаруулах журмаар олгосон.Харин 2025 онд 7 суманд 7 нэгж талбарын 21.58 га газрыг олгохоор төлөвлөснөөс Дэлгэрэх суманд 1 нэгж талбарт төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан боловч оролцох хүсэлт ирээгүй дахин зарласан.	70

2.1.3	2025 оныг "Аялал жуулчлалыг дэмжих" жил болгон зарлах тухай аймгийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамжийн хүрээнд албан байгууллага бүр дотооддоо зорилт дэвшүүлэн ажиллаж, хэрэгжилт, үр дүнг хамтран ажиллах гэрээний биелэлттэй хамт ирүүлэх	Монгол улсын Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтад Эрдэнэ, Замын-Үүд суманд зам дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах зориулалтаар 3 нэгж талбарыг эзэмшүүлэхээр тусгагдсан. Одоогоор газар олгохтой холбоотой шийдвэр гараагүй байна.	50
2.1.4	"Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааны салбар, хүрээг нарийвчлан тогтоох, үндсэн үйл ажиллагаанд хамаарахгүй ажил, үйлчилгээг зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, шилжүүлэх;	2025 оны эхний хагас жилд төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ байхгүй.	-
2.1.5	"Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолд заасны дагуу хотоос хөдөөрүү шилжин суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгч, аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжих зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх	Аймгийн хэмжээнд нийслэлээс хөдөө орон нутагт шилжин суурьшсан 7 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр эзэмшүүлсэн бол 6 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлсэн. Харин Газрын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр газартай холбоотой аливаа хүсэлтийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системээр хүлээн авах, өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн дарааллын дагуу шийдвэрлэхээр хуульчилж, газрын удирдлагын нэгдсэн системд хөгжүүлэлт хийгдсэн тул 2024 оноос дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон. Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаарх санал хүсэлтийг ГЗБГЗЗЕГазарт тавьсан боловч	-

		одоогоор хэрхэн шийдвэрлэсэн, шийдвэрлэх тухай зөвлөмж, чиглэл, шийдвэр ирээгүй.	
2.1.6	"Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд"-д холбогдох мэдээллийг Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал"-ын дагуу боловсруулан оруулах	Хамааралгүй	-
2.1.7	"Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, иргэдийн орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн зохист тэнцвэрийг хадгалах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, энэ хүрээнд уг тогтоолд заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.	Төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын хүрээнд улсын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумдад баригдаж буй төрийн албан хаагчдын орон сууцны барилгуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан. Үүнд: 1. Орон нутгийн төсвийн 1171.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ханги боомтод Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц барих ажлыг "БЭМЭС" ХХК, 467.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах суманд төрийн албан хаагчдын 6 айлын орон сууц барих ажлыг "Зэс-Орд" ХХК-ууд гүйцэтгэж 100% дууссан. 2. Орон нутгийн төсвийн 608.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрэх суманд төрийн албан хаагчдын 6 айлын орон сууц барих ажлыг "Дэлгэр цамхаг өргөө" ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 70%-тай үргэлжилж байна. 3. Улсын төсвийн 4449.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөрийн 1 дүгээр үе шат /Дорноговь аймгийн Айраг, Алтанширээ, Хатанбулаг сум/ ажлыг "Голден ийгл стар" ХХК гүйцэтгэхээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай 2025.05.30-ны өдрийн УТ 2502923326017 дугаартай гэрээг байгуулж, ажил эхлүүлэх бэлтгэлийг хангаж байна.	100
2.1.8	Төсвийн тухай хуулийн 14.2.11-д заасны дагуу нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг оновчтой хуваарилах, ажил, үүргийн давхардлыг арилгах, төрийн бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх	Газрын харилцааны талаарх төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, түргэн шуурхай хүргэх киоск төхөөрөмжийн тоо хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр дахин 1 "Киоск" машиныг Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ азарт байрлуулан үйл ажиллагаанд оруулсан.	100

	үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Газрын харилцааны цахим үйлчилгээний киоск машиныг ашиглан иргэн, хуулийн этгээд нь 52 төрлийн өргөдлийг цахимаар авах, 17 төрлийн мэдээлэл лавлагаа, тодорхойлолтыг хэвлэн авах, цахим хүсэлт өгөх, өргөдлийн явцыг шалгах, цахим гэрээ, гэрчилгээ үүсгэх, газрын төлбөр шалгах, газрын төлбөрөө QR төлөх зэрэг нийт 70 орчим үйлчилгээг чирэгдэлгүй хөнгөн шуурхай авах боломжтой.	
<b>2.2</b>	<b>Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига, ашиг сонирхол үүсэх эрсдлийг бууруулах ажлын хүрээнд:</b>		
2.2.1	Монгол Улсын Төрийн албан ёс зүйн тухай хууль, Засгийн газрын 2024 оны "Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай" 109 дүгээр тогтоолыг удирдлага болгон байгууллагын дотоод журмыг нийцүүлэн батлах, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, төрийн албан хаагч нийгмийг соён гэгээрүүлэгч байх, шударга, ёс зүйтэй харилцаа, хандлагаар иргэдийг үлгэрлэн дагуулах байдлаар нийгмийн нөлөөлөгч байх бодлогыг хэрэгжүүлэх	Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" батлагдсаны дагуу байгууллагын Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус газрын 2024 оны А/47 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос 2025 онд 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн дээд хорооноос танхимын 1 сургалт, төрийн албан хаагч нийгмийг соён гэгээрүүлэгч байх, шударга, ёс зүйтэй харилцаа, хандлагатай холбоотой 8 мэдээллийг дундын мэдээллийн группээр хүргүүлэн зөвлөмж, чиглэлийг өгсөн бол шинээр томилогдсон 3 албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар сахилгын шийтгэл оногдуулсан албан хаагч байхгүй.	100
2.2.2	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлэх, тайлагнах, авлигыг мэдээлэх хэлбэрийг сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр уламжлал болгон зохион байгуулагддаг "Дэвжээ-2025" тэмцээнд заавал оролцох;	Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, газрын даргын 2025 оны А/06 тоот тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны хагас жилийн байдлаар гаргаж ГЗБГЗЗЕГазарт хүргүүлсэн.2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах 5 албан хаагчдад ХАСХОМ гаргах зөвлөмжийг тухай бүр өгч ажиллан, мэдүүлгийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч, баталгаажуулсан.	100

2.2.3	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлийн 2025 оны улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, өмнөх улсын үзлэгийн дүнг өсгөсөн байх	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг гарган 2025 оны 05 сарын 14-ны өдрийн А/25 тоот тушаалаар Газрын даргаар батлуулж, бэлтгэлийг хангаж ажиллаж байна.	50
2.2.4	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан журмын хэрэгжилтийг ханган ажиллах;	Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу албан тушаал, эрхлэх ажил үүргийн дагуу төрийн нууцтай танилцах 2 албан хаагчийн холбогдох материалыг бүрдүүлэн аюулгүй байдлын шалгалтад хамруулах арга хэмжээг авч, нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байна. Тагнуулын ерөнхий газрын Дорноговь аймаг дахь хэлтсээс зохион байгуулсан хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ шат дараатайгаар авч байна. ҮАБЗөвлөлөөс 2003-2024 оны газар олголттой холбоотой судалгааг гаргаж хүргүүлсэн.	100
2.2.5	Төрийн албаны хүний нөөцийг чадавхижуулах, нутгийн захиргааны анхан шатны нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчид болон багийн Засаг дарга нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулах арга хэмжээг Удирдлагын академитай хамтран зохион байгуулах	2025 онд богино хугацааны мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагчийг хамруулсан.	100
2.2.6	Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв", иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулж, хугацааг бууруулах	"Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-д тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 2 өргөдөл гомдол ирүүлснийг хянан үзэхэд 1 гомдол хамааралгүй, 1 гомдол нь үндэслэлгүй тул шийдвэрлэх боломжгүй буцаасан.	100
2.2.7	Байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг	Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх санал	100

	<p>мэргэжлийн байгууллагаар улирал бүр хийлгэн үнэлж, түүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэвшүүлж, үр дүнг тайлагнаж байх</p>	<p>асуулгын хэсгийг байгууллагын <a href="https://domogovi.gazar.gov.mn/">https://domogovi.gazar.gov.mn/</a> цахим хуудсанд байршуулан, иргэд олон нийтээс холбогдох саналыг авч ажилласан. Санал асуулгад нийт 74 хэрэглэгч оролцож, 29 буюу 39.2 хувь сайн, 14 буюу 18.9 хувь нь дунд, 31 буюу 41.9 хувь нь муу гэсэн үнэлгээг өгсөн байна.</p> <p>Харин тус газраас газартай холбоотой үйлчилгээг авч буй иргэдээс үйлчилгээний хүртээмж болон үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн байдалд цаасаар хүлээн авсан 920 судалгаанд дүн шинжилгээ хийхэд нийт санал асуулгад оролцогчдын 90 хувь нь буюу 828 үйлчлүүлэгч тийм гэсэн хариултыг өгсөн. Мөн байгууллагын үйл ажиллагаанд цаашид анхаарах асуудлыг нийт санал асуулгад оролцогчдын 45 хувь нь буюу 414 үйлчлүүлэгч хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох гэсэн бол 30 хувь буюу 276 нь асуудал шийдвэрлэх шат дамжлагыг багасгах, 25 хувь буюу бусад гэсэн хариултыг өгсөн.</p> <p>Судалгааны үр дүнг тулгуурлан цаашид авах арга хэмжээг төлөвлөж байна.</p>	
2.2.8	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, тайлагнах, авлигыг мэдээлэх зааврыг сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр уламжлал болгон зохион байгуулагддаг Дэвжээ-2025 тэмцээнд байгууллага бүр оролцох</p>	<p>Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, газрын даргын 2025 оны А/06 тоот тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны хагас жилийн байдлаар гаргаж ГЗБГЗЗЕГ азарт хүргүүлсэн. АТГазраас бэлтгэсэн 9 шток, инфографик, нийтлэл, зурагт хуудас зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн.</p>	100

2.2.9	Хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон хүний эрхийг хангах, олон улсын гэрээ конвенцийг шийдвэр гаргахдаа үндэслэн хэрэгжүүлэх, эрхийн зөрчил болон бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг газрын даргын 2025 оны А/07 дугаар тушаалаар байгуулж, эрхийн зөрчил болон бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулан хамт олноор хэлэлцүүлж, журмыг газрын даргын 2025 оны А/24 дугаар тушаалаар шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.	100
2.2.10	Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	<p>Байгууллагын мэдээллийн нийтэд хамааралтай мөрдөгдөж буй тушаал, шийдвэр, журам болон цаг үеийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудсанд тогтмол тухай бүр шинэчлэн байршуулж ажилласан.</p> <p>Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх видео контентийг олон нийтэд хүргэх зорилгоор орон нутгийн <b>DTV телевизээр түүний Facebook хуудсаар</b> дамжуулан видео контентыг түгээсэн нь иргэдийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж, иргэдийн газрын цахим үйлчилгээний талаарх ойлголт, мэдлэг нэмэгдсэн ба <b>egazar.gov.mn</b> системийн хэрэглээний идэвх 20 %-аар өсч, иргэдийн хүсэлтийн алдаатай илгээлтүүдийн тоо буурсан. <b>QR код бүхий үйлчилгээний заавар, видео тайлбар</b> бүхий гарын авлага материалыг сайт болон фэйсбүүк хуудсанд, байгууллагын хүлээлгийн танхимд байршуулсан.</p> <p>Олон нийтийн цахим сүлжээгээр салбарын цаг үе, үйл ажиллагаатай холбоотой 243 мэдээлэл орж уг мэдээллийг өдөрт дунджаар 316 хүн хандаж үзэж байгаа нь сард 9480, өнөөдрийн байдлаар өссөн дүнгээр 56880 хүн байгууллагын вэб хуудаснаас мэдээ мэдээлэл авсан ба иргэдийн зүгээс зэрэг сэтгэгдэл, "хялбар болсон" гэх сэтгэгдэл ирсэн байна.</p>	100
2.2.11	Монгол хэлний тухай стандартыг мөрдүүлэх, төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудтай	Албан хаагч бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдлэг чадвараа хөгжүүлэх хэсэгт монгол хэл бичгийн мэдлэгээ дээшлүүлэх арга хэмжээг тусган, албан хаагч бүр үндэсний бичгийг бие даан судалж, мэдлэг чадвараа хөгжүүлсэн.	100

	хамтран зохион байгуулах		
2.2.12	Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-ний хэрэгжилтийг хангаж ажиллах	"Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах Жендерийн талаарх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, газрын даргын тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг хагас жилээр ГЗБГЗЗЕГазарт тайлагнасан.	100
2.2.13	ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх модуль I,II сургалтыг зохион байгуулах	ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх модуль I, II сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй.	-
<b>2.3</b>	<b>"Цахим Дорноговь" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:</b>		
2.3.1	Төрийн үйлчилгээг цахимжуулах, оновчлох, загварчлах, нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж, тухайлбал Газрын тухай хуулийн 32.1- д иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтээ цахим систем болон төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээр дамжуулан гаргахаар өөрчлөлт орсонтой холбогдуулан газар эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээд газартай холбоотой тухайлбал газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа сунгах, хэмжээ, байршил, зориулалт өөрчлөх, барьцаалах, бусдад шилжүүлэх хүсэлтээ e.gov.mn цахим хуудсанд хандан илгээх 11 заавар зөвлөмжийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Газрын удирдлагын нэгдсэн системд аймгийн хэмжээнд нийт 627 иргэн, хуулийн этгээдээс хүсэлт ирүүлснээс 491 хүсэлтийг шийдвэрлэж, шаардлага хангаагүй 72 хүсэлтийг буцаасан бол судлагдаж байгаа 64 хүсэлт байна.	100
2.3.2	Төрийн болон төрийн өмчит байгууллагад албан хэрэг хөтлөлт, дотоод удирдлагын программ хангамжийг нэвтрүүлэх, албан бичиг солилцооны дундын системийг бүрэн ашиглах, хэвшүүлэх;	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд (Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн) "ERP" мөн "ABLE" (Байгууллагын удирдлагын цогц онлайн систем)-ийг бүрэн нэвтрүүлж, 2025 оны хагас жилийн байдлаар 786 албан бичгийг хүлээн авч, 460 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.	100

2.3.3	Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөх, нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд (Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн) "ERP" мөн "ABLE" (Байгууллагын удирдлагын цогц онлайн систем)-ийг бүрэн нэвтрүүлж, 2025 оны хагас жилийн байдлаар 786 албан бичгийг хүлээн авч, 460 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан. Газар эзэмших, ашиглах болон түүнтэй холбогдсон нийт 627 хүсэлтийг хүлээн авснаас 491 хүсэлтийг шийдвэрлэж, 72 хүсэлтийг цуцалсан бол 64 өргөдөл шийдвэрлэгдээгүй байна.	100
2.3.4	Цахим орчинд хүүхэд хамгаалах чиглэлээр арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн оролцоог хангах;	Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс гар утасны хэрэглээг хязгаарлах тохиргооны төрлүүд, хүүхдүүдийн байршил тодорхойлох апп суулгах, ашиглах зааварчилгааг хэвлэн нийт албан хаагчдад өгч ажилласан.	100
2.3.5	Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, нэгдсэн цахим хуудас <a href="http://www.gov.mn">www.gov.mn</a> мэдээллээ байршуулж, хэвших	Байгууллагын вэб хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр салбарын цаг үе, үйл ажиллагаатай холбоотой 243 мэдээлэл орж уг мэдээллийг өдөрт дунджаар 316 хүн хандаж үзэж байгаа нь сард 9480, өнөөдрийн байдлаар өссөн дүнгээр 56880 хүн байгууллагын вэб хуудаснаас мэдээ мэдээлэл авсан ба иргэдийн зүгээс эерэг сэтгэгдэл, "хялбар болсон" гэх сэтгэгдэл ирсэн байна.	100
2.3.6	Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, цахим орчны зохистой хэрэглээг хэвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахад Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллах;	Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан шинээр газар эзэмших хүсэлт гаргах, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй танилцах, өөрийн эзэмшил газартай холбоотой цахим хүсэлт илгээх, мөн барилга барих зөвшөөрөл авахтай холбоотой 5 инфографик, нийтлэл, зурагт хуудсыг байршуулан олон нийтэд хүргэж, нийт 184 хандалтыг авсан бол газар эзэмших, ашиглахтай холбогдсон үйлчилгээ авсан 137 иргэн, хуулийн этгээдэд зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан.	100
2.3.7	Төрийн болон орон нутгийн байгууллагууд цаасны хэрэглээг багасгах, байгууллагын дотоод үйл ажиллагаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах замаар ажлын бүтээмжийг дээшлүүлэх, "Төрийн болон	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд (Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн) "ERP" мөн "ABLE" (Байгууллагын удирдлагын цогц онлайн систем)-ийг бүрэн нэвтрүүлж, 2025 оны хагас жилийн байдлаар 786 албан бичгийг хүлээн авч, 460 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.	100

	нутгийн өөрөө удирдах байгууллагуудад хэрэглэх боломжтой цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний зөвлөмж"-ийн хавсралт жагсаалтад буй программ хангамжуудаас сонгон хэрэглэх		
2.3.8	"Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг цонхны бүртгэлийн систем"/mindmongolia/-аас худалдан авах	Хүлээгдэж буй гүйцэтгэл	-
2.3.9	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагуудын мэдээллийг эБПеп.до <sup>^</sup> .тп цахим хуудсаар байнга ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	Шилэн дансны тухай хуулийн дагуу сар болгоны 7-ны өдрийн дотор Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой нийт 162 мэдээ тайланг шаардлагатай материалыг хавсарган хугацаанд бүрэн байршуулж ажилласан.	100
2.3.10	Цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс тодорхой төслүүдийг хамтран хэрэгжүүлэх, харилцаа холбоо, мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, бүртгэл хөтлөх	Газрын биржийн цахим системийн шинэчилсэн 3.0 хувилбарын талаарх ГЗБГЗЗЕГазраас бэлтгэсэн инфографик, нийтлэл, зурагт хуудсыг тухайн орон нутгийн нийгмийн сүлжээ /фэйсбүүк/, байгууллагын цахим хуудсанд 2 удаа байршуулан олон нийтэд хүргэж, нийт 289 хандалтыг авсан. Мөн ГЗБГЗЗЕГазрын Газрын биржийн хэлтэстэй хамтран 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдрүүдэд сумын Газрын даамлуудад сургалт хийж, газрын биржийн цахим системийн шинэчилсэн 3.0 хувилбарыг үйл ажиллагаандаа ашиглах, иргэнд олон нийтэд таниулах, нээлттэй ил тод мэдээллээр үйлчлэх талаар холбогдох зөвлөмжийг өгч ажилласан.	100
<b>2.4</b>	<b>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд</b>		
2.4.1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 58 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 23-	Байгууллагын эзэмшил газарт тарьсан модны арчилгаа, усалгааг тогтмол хийж ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан.	100